



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/47.

Ховд

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, 29.2, Дайчилгааны тухай хуулийн 18 дугаар зүйл, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын н/203 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн дайчилгааны заавар”-ын 2 дахь хэсгийн 2.1.3, 2.2.1, 2.2.6, “Дайчилгааны бэлэн байдлыг хангах №600/02 дугаар удирдамж”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарыг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”-г 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Дарга:	Б.Ганхуяг	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа
Гишүүдэд:	Б.Ганболд	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Х.Батцэцэг	- Аймгийн Татварын хэлтсийн дарга
	Д.Даваасамбуу	- Аймгийн Статистикийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Н.Ирэхзаяа	- Аймгийн Автотээврийн төвийн дарга
	Х.Энхболд	- Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч, хурандаа
	Б.Баянжаргал	- Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 305 дугаар салбарын захирагч, хошууч

Б.Мөнгөнцоож - Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт,  
сургалтын офицер, дэд хурандаа

Ж.Нямжаргал - Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер,  
хошууч

Нарийн бичгийн

дарга: Д.Одгэрэл - Цэргийн штабын дайчилгааны офицер,  
дэд хурандаа

2. “Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарыг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө” зааврын дагуу боловсруулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Төлөвлөгөө боловсруулах явцад төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцлалын горимыг чанд баримтлан, хүн нэг бүрээр нууцын баталгаа гаргуулах ажиллахыг Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер /хошууч Ж.Нямжаргал/-т даалгасугай.

4. “Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарыг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”-г заагдсан хугацаанд Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар батлуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, ажлын хэсгийн дарга /хурандаа Б.Ганхуяг/-д даалгасугай.

5. Төлөвлөгөө боловсруулахад шаардагдах 830 800 төгрөг /найман зуун гучин мянга найман зуун/-ийг аймгийн Засаг даргын Нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

6. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, ажлын хэсгийн дарга /хурандаа Б.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
02 дугаар сарын 03-ны өдрийн  
А/47 дугаар захирамжийн  
1 дүгээр хавсралт



ДАЙЧИЛГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД  
ШААРДЛАГАТАЙ ТӨСВИЙН ЗАРДЛЫН ТООЦОО  
/төгрөгөөр/

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Газрын зураг /1*100000/	Ширхэг	2	300 000	600000
2	Бичгийн цаас	Боодол	2	15 000	30000
3	Притерийн хор	Ширхэг	2	35 000	70000
4	Өнгийн бал	Боодол	2	8000	16000
5	Өнгийн харандаа	Боодол	2	15000	30000
6	Тодруулагч	Боодол	2	11000	22000
7	Калькан цаас	Боодол	1	8000	8000
8	Цаасны цавуу	Ширхэг	4	2000	8000
9	Баримт бичгийн хавтас	Боодол	1	16000	16000
10	Баримт бичгийн нуруу	Ширхэг	36	300	10800
11	Фото цаас	Боодол	1	20000	20000
Нийт дүн				430 300	830 800

-oOo-